



ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 39

Мандалговь


Хөрөнгө данснаас хасах тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.г дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3,326,763 /гурван сая гурван зуун хорин зургаан мянга долоон зуун жаран гурав/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн хөрөнгийг хавсралтын дагуу акталж устгахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, ОНӨА-ны хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга Д.Доржсүрэнд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2015 оны 04 сарын
01 өдрийн 39-р тогтоолын хавсралт



Акталж устгах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Ашиглалтанд орсон он	Үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Компьютер 2008	1	2008.12.16	610,100.0	610,100.0	610,100.0	0
2	Компьютер 2	1	2004.01.01	1,449,363.4	1,449,363.4	1,449,363.4	0
3	Компьютер	1	2006.01.01	632,700.0	632,700.0	632,700.0	0
4	Морин хуур	1	2006.02.27	140,600.0	140,600.0	140,600.0	0
5	Морин хуур	1	2012.12.12	494,000.0	494,000.0	494,000.0	0
Нийт дүн					3,326,763.4	3,326,763.4	0